

Др.Обрущанский Борбала


МОНГОЛЫН

түхэй




ЭРТНИЙ УНГАРЫН

Түрхэн тэмдэглэл



Др.Обрущанский Борбала

МОИГОЛЫН
тухай



ЭРТНИЙ УНГАРЫН
Түүхэн тэмдэглэл

Улаанбаатар
2022 он



Монголын тухай эртний Унгарын түүхэн тэмдэглэл

*ННА 63
ДАА 900*

Др.Обрущанский Борбала

МОИГОЛЫН *тухай*



ЭРТНИЙ УНГАРЫН *Түүхэн тэмдэглэл*

Унгар хэлнээс монгол хэлнээ хөрвүүлсэн:

Др.Обрущанский Борбала

Хянан тохиолдуулсан:

**Гэндэнжамцын Хишигбадам
Гурдагвын Энхтөр**

Хэвлэлийн эхийг:

Т.Бат

"Хүслийн өнгө" ХХК-д хэвлэв.

ISBN 978-9919-9372-3-2

Улаанбаатар
2022 он





МОНГОЛЫН ТУХАЙ ЭРТНИЙ УНГАРЫН ТҮҮХЭН ТЭМДЭГЛЭЛ

Др.Обрушанский Борбала

Хураангуй: Дэлхийн монголч эрдэмтэд Плато Карпини бол Монголын эзэнт гүрний нутагт ирсэн Европын анхны аялагч бөгөөд Монголын шинэ эзэнт гүрний талаар дэлгэрэнгүй тайлбар өгсөн анхны хүн гэсэн ойлголттой байдаг.¹ Гэтэл түүнээс арван жилийн өмнө эртний Унгарын Загалмайн шашны доминикан лам Юлианус Унгаруудын өвөг дээдэс, удам угсааг хайхаар Европоос зүүн тийшээ явж, Монголчуудын тухай хамгийн анхны мэдээллийг Ромын хамба ламд хүргэсэн юм.² Өдгөө миний бие доминикан ламын бичсэн тэрхүү түүхэн тэмдэглэлийг монгол хэлээр орчуулан хүргэж байна.

Юлианус гэдэг хүний амьдралын тухай түүхэн эх сурвалжийн мэдээлэл бага байдаг. Учир нь түүний намтрыг тухайн үед бичиж үлдээгээгүй. Тэрээр загалмайн шашны доминикан урсгалын лам байсан гэдэг нь тодорхой байна. Ласло Бендефи хэмээх эрдэмтэн, Юлианус бол Италийн Бологна хотод сурч байсан хэмээх таамаглал дэвшүүлжээ.³ Тэр унгар хүн байсан уу эсвэл гадны хүн байсан уу гэдэг нь тодорхой бус. Ямар ч байсан унгар болон эртний куман хэл мэддэг байсан гэдэг нь лавтай байна. Тэрбээр ирээдүйн аяллынхаа хүнд бэрхийг тооцоолон мэдсэн, бэрхшээл саадыг давж чадна гэдгээ ч мэдсэн, хамгийн багаар бодоход 20-иос дээш настай, ойролцоогоор 30-35 орчим настай байсан бололтой.⁴

- 1 Өнөөдрийн Монголын түүх судлаачдын дунд цөөхөн хүн уг сэдвийг судлан өгүүлэл бичсэн боловч Юлианус ламын намтар, үйл ажиллагааг олонх монголч эрдэмтэд огт мэдэхгүй байна.
- 2 Энэ тухай Монголын түүх судлаачдаас цөөхөн хүн бичсэн бөгөөд Юлианус ламын намтар, үйл ажиллагааны талаар ихэнх нь огт мэдэхгүй байна. L.Dörrle 1956. Sinor 1952
- 3 Bendefy, 1936.
- 4 Түүхэнд тэмдэглэсэнээр, доминикан ламын санваарыг 20-иос дээш насны хүн авдаг дүрэмтэй байсан.






Загалмайн шашны доминикан урсгал бол дорно дахины улс орнуудад нэлээд түгэн тархсан бөгөөд Юлианус энэ үйл хэрэгт багагүй үүрэг гүйцэтгэсэн. Түүний үүсгэн байгуулагч нь Доминик. Тэрээр энэ урсгалыг XIII зууны эхээр үндэслэсэн бөгөөд бадар барин, өргөл буяны үйл хийх дүрмийг тогтоосон. 1216 онд Ромын хамба лам III.Хонориус баталж, тэр үеэс албан ёсоор түгэн дэлгэрсэн урсгал юм.

Тухайн үеийн Унгарт доминикан урсгалын лам нар маш олон байсан бөгөөд энэхүү үйл ажиллагаанд Бологна хотод шашны хуулийг судалж байсан Паулус гэдэг хүн чухал үүрэг гүйцэтгэсэн байна. Доминик 1221 онд Паулусийг Унгар руу явуулан тэнд загалмайн шашныхаа урсгалыг амжилттай дэлгэрүүлж, цаашлаад дорно зүгт эртний кумануудын нутаг руу явуулсан боловч тэдэнд хөөгдөн нутгаас нь гарсан. Тэд цааш Днестер мөрөнд очсон, гэхдээ харамсалтай нь тэнд номлогч нар нь нөхдийнхөө хамт амиа алдсан юм. 1220 оны үед олон улсын харилцааны шинэ эрин эхэлсэн нь куманууд болон загалмайн шашинтны харилцааг өөрчилж чадсан байна. 1222-1223 онд монгол цэрэг Кавказаар дамжин Зүүн Европын тал хээр нутагт нэвтэрч, Калка голын орчимд куман, оросын хамтарсан цэргүүдийг ялсан ба ялагдсан кумануудын нэг хэсэг нь Унгарын хаант улсад дагаар орох зөвшөөрлийг II.Андраш хаанаас хүссэн. Ингээд 1228 онд Куманы толгойлогч нар зөвшилцөж байгаад Унгарын хаант улсын бүрэн эрхт байдлыг хүлээн зөвшөөрөн нутагт нь суурьшиж, загалмайн шашныг нь хүлээн авна хэмээн амлажээ.

Дараагийн жил буюу 1229 онд Роберт хэмээх Унгарын хамба лам Куманиа /өнөөгийн Румын улсын Молдвагийн Милко гэдэг нутаг/-д шашны төв үүсгэн байгуулж, Унгарт дагаар орсон кумануудыг загалмайн шашинд оруулсан байна. Тухайн үед Унгарын II.Андраш хаан нь Куманийн хан цол авсан юм.⁵ Тэр хотыг дорно зүгт гарах шашны төв болгосноор тэндээс доминикан лам нар маш олон чиглэлд аялал хийсэн бололтой. Тэдний үйл ажиллагааны талаар мэдээлэл маш бага үлдсэн байна. II.Андраш хааны хүү IV.Бела аавынхаа үйл ажиллагааг үргэлжлүүлэн хаан ширээнд сууснаар загалмайн шашныг зүүн зүгт дэлгэрүүлэх ажлыг нилээд зоригтойгоор төлөвлөж удирдсан байна.

5 „primogenitus regis Hungarie et Cumanie” Бела хаан бол 1235 он хүртэл Унгарын хаант улсын зүүн гарын удирдагч байсан, 1235-1270 оны хооронд хаан ширээнд сууж байсан.





Доминикан лам нар эртний сурвалжуудаас судлаад дорно дахины унгаруудын оршин сууж байсан газар нутгийг багцаагаар Азовын тэнгисийн зүүн хэсэгт байсан бололтой хэмээн тодорхойлсон. Мөн тэдний оршин сууж байсан газрын мэдээллийг дүрвэж ирсэн кумануудаас ч бас авсан байх магадлалтай. Доминикан лам нар дорно зүг рүү төлөөлөгч явуулах шийдвэр гаргасан. Бела хаан хүү тэдэнд дэмжлэг үзүүлэн гурван доминикан ламыг тийшээ явуулсан боловч гурван жилийн дараа зөвхөн Отто гэдэг лам нь маш хүнд өвчтэй болон буцаж ирээд, явсан газрынхаа тухай мэдээлэл өгөөд нас барсан байна.⁶ Түүний аяллын цаг хугацаа тодорхой биш бөгөөд судлаачдын үзэж байгаагаар 1231-1234 оны хооронд байсан бололтой.⁷ Отто лам аяллынхаа үеэр анх дорно зүгт үлдсэн унгаруудтай уулзаж ярилцсан бөгөөд тэдний тухай нилээд дэлгэрэнгүй мэдээллийг олсон байж магадгүй. Энэ нь Юлианус ламын аяллын бэлтгэл болсон байх.

Юлианус ламын анхны аялал нь 1235-1236 оны хооронд байсан тухай доминикан урсгалын түшмэл лам Ричардус хэмээх хүн латин хэл дээр бичсэн бол одоо таны уншиж буй 1237-1238 оны үед хийсэн түүний хоёр дахь аяллын “Татаруудын аж амьдралын тухай бичсэн захидал” хэмээх тэмдэглэлийг Юлианус өөрөө бичиж, Ромын хамба ламд илгээсэн юм. Уг захидал Ватиканы архивын гар бичмэлийн фондод байсныг 1695 онд Унгарын Есуит урсгалын Челеш Мартон гэдэг лам олсон хэмээжээ.⁸


Юлианус гурван ламын хамт Оттогийн явсан замаар аялсан. Тэд 1235 оны тавдугаар сарын эхээр Кавказ руу хөдөлжээ. Эхлээд Константинополь руу явганаар болон мориор явж, тэндээсээ Хар тэнгисээр усан онгоцоор дамжин Крымын зүүн буланд байх Матрикс⁹ хотод очсон. Энэ хот нь хүрэл зэвсгийн үеэс эхлэн нүүдэлчин улсуудын буюу скиф, кумануудын амьдарч байсан төв нутаг юм. Энэ газрын нэр нь МЭ-ний 8-р зууны үед оршиж байсан “Хунгариа” буюу Унгар улс мөн бөгөөд тэнд “Оногүриа” нэртэй

6 Юлианус ламын анхны тэмдэглэл. In: Katona, 1983.

7 Тэд Юлианус ламын аяллаас яг гурван жилийн өмнө аялалд явсан. Эндээс Унгарын судлаач нар түүний цаг хугацааг тооцоолон гаргасан.

8 Thesaurus Bullarum, brevium ecclesiac Hungaricae jura privilegia, historiam spectantia (Kaprinai gyűjt. A. XII-XIV. k.) https://library.hungaricana.hu/hu/collection/konyvtaridok-egyetemikonvyvtar_hkp_kaprinai_b/

9 Одоогийн Орос улсын Таман гэдэг хот.






Загалмайн шашинтны хамба ламын төвийг үүсгэн байгуулсан.¹⁰ Энэ үеэс эхлэн Юлианус болон түүний гурван хамтрагчийн аялсан замыг сэргээн тодорхойлж болно. Тэд зүүн зүг рүү аялан явж, Алан улсын Толбикан хотод хагас жил гаран амьдарсан. Тухайн үед Алан улсын хөрш нь монгол/татарууд байсан учраас аланчууд тэднээс айхдаа Юлианус болон хамтрагч нарт зам зааж өгөөгүй. Ийм нөхцөл байдлын улмаас хоёр лам нь Унгар руу буцаж, Юлианус лам Герхардустай үлдээд дараа нь ямар нэгэн нүүдэллэж буй хүмүүстэй хамт хойд зүгт явжээ. Тэр Монгол цэргийн байдлыг тандахаар гэнэт хойд зүг рүү чиглэн буцаж явсан бололтой. Тэд Ижил мөрний Болгаруудын нутагт очихдоо монгол/татарын цэрэг тэнд байрлаж байгааг олж мэдсэн. Тэнд Юлианус татарын элчтэй уулзаж ярилцсан байна. Тэрээр орос, куман, герман, араб зэрэг хэлээр ярьдаг байв. Тэдгээр монгол/татар цэрэг Болгар хот тэндээс таван өдрийн зайтай байна хэмээжээ. Мөн урд зүгт байх Перс улсыг эзлээд тэд дэлхий даяарх бүх угсаатнуудыг эзлэхээр төлөвлөсөн гэхийг сонссон Юлианус хаандаа мэдээлэл дамжуулахаар нутаг руугаа яаран буцсан. Тэрээр 1236 оны 12-р сард Унгарт ирээд Монголчуудын бүх дэлхийг эзлэн түрэмгийлэх болон загалмайн шашныг устгах төлөвлөгөө зэргийн тухай IV.Бела хаан болон түүний шашны хамба ламд хэлсэн. Доминикан урсгалынхан дараа жил нь дахин дөрвөн ламыг зүүн тийшээ явуулсан. Тэд нар Юлианусын заасан замаар явсан боловч яг заасан газарт нь хүрч чадаагүй. Учир нь тухайн үед Бат хаанаар удирдуулсан цэрэг Ижил мөрний Болгарын хаант улсыг дайрч эзэлсэн байлаа. Тэрээр 1237 оны хавар Ромоос ирснээсээ хойш хоёр дахь удаагийнхаа аялалд гурван нөхдийн хамт явсан боловч зорилго нь шашин дэлгэрүүлэхээр биш тагнуулын зорилгоор очоод монгол болон татарын түүх, соёл, аж амьдрал, уламжлалын тухай дэлгэрэнгүй мэдээлэл цуглуулж, доорх мэдээллийг бичсэн байна.

Тэрбээр монгол цэргийн төлөвлөгөөг ч мэдсэн. Тэд гол хөлдөхийг хүлээгээд дараа нь шууд орос ханлигуудыг довтолно гэж сонсов. Монголчууд гол мөрөн хөлдсөний дараа Оросууд руу довтолж эхэлснээр түүний сонссон мэдээ үнэн болохыг нотолсон юм. Юлианус 1237-1238 оны өвөл Бат хааны маш чухал захиаг

10 Куман болон Унгарууд МЭ-ний 2-8-р зууны хооронд Кавказын уулын бүс нутагт амьдарч байсан. Уг уулын умард хэсэг ба Азовийн тэнгисийн зүүн эрэг дээр “Хунгариа” гэдэг гүрэн байсан хэмээх мэдээлэл тухайн үеийн түүхэн сурвалжуудад тодорхой байна. Обрущанский, 2018





Монголын тухай эртний Унгарын түүхэн тэмдэглэл

өвөртлөн гэртээ ирэв. Зам зуурт нь монгол цэрэг урагшаа дайралт хийж, кумануудыг довтолж ялсан. Тэр үеэр 40 мянга гаруй куманууд Көтөн нэртэй хаантайгаа хамт зугтаж, Унгарт очиход загалмайн шашнаа хүлээн зөвшөөрүүлэхийн тулд IV.Бела хаан тэднийг нутагтаа оруулсан. IV.Бела хаан кумануудыг монгол цэргийн эсрэг өөрийнхөө цэргийн хүчийг зузаатгахад чухал үүрэгтэй гэж бодсон байх. Юлианус ламын хоёрдахь аяллын тухай мэдээ монгол хэл дээр хэвлэгдээгүй байгаа тул өдгөө Бат хаан болон монголчуудын тухай тэдний юу мэдэж байсныг дэлгэн толилуулж байна.





ТАТАРУУДЫН АЖ АМЬДРАЛЫН ТУХАЙ БИЧСЭН ЗАХИДАЛ¹¹

Загалмайн шашныг хүндэтгэж, Эцэг Тэнгэрийн ивээлээр Перуг мужийн тэргүүн хамба лам ба Ромын хамба ламын төлөөлөгчид Юлианус нэртэй Унгарын доминикан урсгалын элч лам, санваартны боол би энэхүү тэмдэглэлийг хүндэтгэлтэйгээр бичиж байна. Би бээр Таны зараалын дагуу элч лам нартайгаа уугуул Их Унгар нутаг руугаа зааж өгсөн маршрутын дагуу аялах хүсэлтэйгээр явсан. Прүс улсын¹² хамгийн цаад талд хүрэлцэн очоод үнэн байдлыг мэдэж авсан. Маш гашуун, хүн болгоныг цочирдуулсан хэрэг болсон. Уугуул унгарууд мөн Ижил мөрний болгаруудыг тартарчууд гэдэг ба татарууд тэднийг болон хэд хэдэн улсыг бүрмөсөн сүйтгэв.¹³

Харин татарууд гэдэг нь яг хэн бэ? Тэдний тухай би энэ хэдхэн мөрөнд өөрийн мэдэхийнхээ хэрээр хүүрнэе. Нэг хэсэг хүн надад ингэж хэлсэн: татарууд одоогийн кумануудын амьдарч байсан тэр газар нутгийг эзэмшиж байсан. Үнэндээ тэд нарыг Измаелын залгамжлагч гэдэг байсан учраас тэднийг одоо измаелита гэж нэрлэхийг хүсч байна.¹⁴ Тэдний орхиж нүүсэн нутгийг Гутта гэдэг, Рубен ч бас Гутта гэж нэрлэдэг.¹⁵ Татаруудын анхны дайн ийн эхэлжээ. Гутта нутгийн эзэн Гүр хаан байсан,¹⁶ түүний аав ээжийг

11 Загалмайн шашны лам Юлианусын 2-р дугаар аяллын тэмдэглэл 1237-1238 оноос


12 Прүс улс нь одоогийн Герман улсын зүүн хойд талд байна.

13 Унгарууд болон Болгарууд ч Европын нилээн том газар нутгийг эзлэн амьдарч байв, түүний нэг нь Кавказын уулсын наад талын одоогийн баруун Азербайжан юм. Тэднээс хэсэг бүлэг хүн хойшоо нүүж, Казань хотын орчимд суурьшжээ. Юлианус тэд нартай уулзаж, татаруудын тухай мэдээ цуглуулав.

14 Дундад зууны үеийн Ариун номонд Гарал үүслийн 16, 11-12-ын дагуу догшин ааштай Измаел залгамжлагч гэж тодорхойлов. Оросын тэмдэглэлд татаруудыг байнга Измаелита гэж нэрлэдэг байв.

15 Гутта-Гутхиа бол Хятад гэсэн үг, орос хэлээрр Китай гэдэг. Европод үл мэдэгдэх нэрийг Гут буюу германчуудтай хольжээ.

16 Gurgatan, Gurguta, Gurgutha. Уг нэр нь монголын Гүр хаан мөн. Тэр нь Хятан нарын Гүр хаан байх ёстой. Түүнийг монгол түүхийн сурвалжид ч Гүр хаан гэж тэмдэглэдэг.





нас барсны дараа нөхөргүй эгч нь гэр бүлийн тэргүүн болсон ба тэр эгч нь эр хүн шиг зан араншинтай гэнэ. Хөрш аймгаа дайрч эзлээд, өмч хөрөнгийг нь булаан авсан. Хэсэг хугацааны дараа татарууд түрүүчийнхээ хөршийг дахин довтлохыг хүссэн боловч тэр аймгийн хан нь түрүүлж мэдээд эгчтэй нь тулалдсан. Хөршүүд нь тулаанд ялж, тэднийг олзлохуйд зарим нь зугтсан, харин эгчийг нь барин, хүчирхийлсний дараа толгойг нь авч егүүтгэв.¹⁷

Үүнийг сонссон Гүр хаан хөрш хандаа элч илгээж, дараах мэдээг хүргүүлэв: “Олонд авсан эгчийг минь маш ихээр доромжлон амийг нь егүүтгэсэн гэдгийг мэдлээ. Үүнээс үүдэн чи надтай дайсан болсон гэдгээ мэдэж ав. Хэрвээ эгч минь чамд болон өмч хөрөнгөнд чинь ямар нэгэн хохирол учруулсан бол чи надад хандаж, шударга шийдвэрийг гаргуулж болох байсан. Хэрвээ чи ялсан бол, өөрийн гараар шийтгэхийг хүссэн бол эгчийг минь ингэж доромжлохын оронд эхнэрээ болгон авсан нь дээр байсан. Хэрвээ чи түүний амийг хороох л хүсэлтэй бол доромжилж болохгүй байсан. Чи түүнийг хүчиндэж, дараа нь цаазаар авч хоёр удаа шийтгэсэн нь миний нандин сэтгэлийг маш ихээр сэвтүүлэн бузарлалаа. Чи эгчийн минь аминд хүрсэн тул би бүх цэргийнхээ хүчээр чамайг довтлох болно гэдгийг чи сайн мэдэж ав!

Үүнийг сонссон алуурчин хан эсэргүүцэж чадахгүйгээ мэдээд эзэлж авсан нутгаа орхин хүмүүстэйгээ хамт Орнахын султан руу дүрвэн зугтав. Энэ үед Кумануудын нутаг¹⁸ Витхут¹⁹ гэдэг нэртэй хан амьдарч байсан бөгөөд түүний эд хөрөнгө, баялагийн тухай үлгэр домог мэт яриа дэгдсэн байв: хээр талд байгаа адуу мал нь хүртэл алтан тэвшнээс ус ууж байна гэнэ. Энэ тухай Бух голын²⁰ эрэг хавиар нутаглаж байсан Гүрэг гэдэг куман удирдагч


Юлианусын тэмдэглэлд бичсэн Гүр хаан нь “Чингис хаан” мөн.

17 Хорезм улсын төв Орнах гэдэг хот нь дундад зууны үеийн Үргенч гэв. Тэнд Ала-Ад-Дин Мухамед амьдардаг. Түүний оронд эгч нь улсаа захирав. Жувайнигийн мэдээгээр Көк нэртэй хан султанаас зугтаж, султаны нэгэн хэсгийн удирдагч болов.

18 Terra Cumanorum нь Евразийн баруун хэсэг, Зүүн Европын тал нутаг мөн. Тэдний уугуул нутаг бол Дундад Ази юм.

19 Withut нэр нь уйгарын Идикүттай төстэй. Уйгурууд нь 1209 он хүртэл Хар Хятаны харьяалалд байхдаа босож, Чингис хааны улстай нийлэв.

20 Уг голын нэрийг Унгар болон Европын судлаач нар мэддэггүй. Гүрэг нь Найманы Гүчүлүгтэй харьцаж байсан байж болно. Тэр хадам эцгийг баривчлан 1211-1218 оны үед Хар Хятаны ханы оронд суув. Чингис хааны цэрэг 1218 онд уг газрыг эзлэн авав.





сонсоод түүнийг довтлон ялав. Тэд Витхутыг ялсныхаа дараа хоёр хүүтэйгээ болон цөөн тооны өөрийн шадар хүмүүстэйгээ тулалдааны талбараас Орнахын султан руу дүрвэн очив. Тэд хөршүүд байсан хэдий ч султан нэгэн цагт тэдний үйлдсэн шударга бус явдлыг санан толгойлогчийг нь хаалган дээрээ дүүжлэн, ард түмнийг нь эрхшээлдээ оруулав.

Витхутын хоёр хүү нь шууд зугтсан боловч өөр зам байхгүй учир аавыг нь болон өөрсдийг нь дээрэмдсэн Гүрэг хаан руу буцан очив. Гэвч уурандаа хөтлөгдсөн хаан том хүүг морьтой нь хөнөөхүйд балмагдсан бага хүү нь татарын Гүр хаан руу зугтан очиж, эцгийг нь тонож, ахыг нь алсан Гүрэгээс өшөө авч өгөхийг гуйв. Бүх зүйл түүний хүссэнээр болсон.

Ялсны дараа бага хүү нь Гүр хаанаас дахин өршөөл эрэн аавыг нь хороосон Орнахын султанаас өшөө авч өгөхийг хүсэв. Ингэхдээ аавынх нь үлдээсэн албатууд тэдний барьцаанд байгаа ба тэд тусална гэв. Тэд хоёр удаагийн ялалтынхаа дараа сэтгэл ханан найрлаж, тэр эрчээрээ Орнахын султаныг дайран ялав. Ингэж татаруудын удирдагч Гүр хаан бүх л газар ялалт байгуулаад цааш явж Персүүдийн эсрэг тулалдав. Тэнд ч бас үлэмж ялалтыг байгуулснаар Персийг бүрмөсөн эзлэв.²¹


Түүний дараа тэрээр бүр ч зориг орж, өөрийгөө хамгийн хүчирхэг нь хэмээн мэдэрч, бүх дэлхийг эзлэхийн тулд бусад орнуудын эсрэг довтолгооноо эхлүүлэв. Ингээд кумануудын нутаг руу довтолж, бут цохин газар нутгийг нь эзлэн авав.²²

Тэндээс буцаж, унгаруудын уугуул нутаг болох Их Унгарын нутаг руу явсан. Тэдэнтэй 14 жил тулалдаж, 15 дахь жилдээ тэднийг ялсан. Энэ тухай зэрлэг нүүдэлчин унгарууд бидэнд ярьсан.²³ Тэднийг бут цохисныхоо дараа баруун тийшээ эргэж, нэг жил илүү хугацаанд бас нэгэн нүүдэлчид болох Саксин, Меровиа, Болгар улсуудыг эзэлж, 60 том цайзыг өөрийн болгов. Эдгээр

21 Перс гэдэг газар нутагт заримдаа Кавказын бүс нутагт ч оршиж байжээ.

22 Сүбэдэй болон Зэв хоёр Персийн урд талаас хойшоо чиглэлд дайрч, Кавказын цаад талд хүрээд, хэдэн том цайзыг бүслэн авав. Яг тэр нутагт аланууд Кавказын Унгаруудтай хамт амьдарч байв. Тэндээс бүр хойшоо нүүхдээ 1222 онд орос, куман цэрэгтэй хамтран дайрч ялав.

23 Зүүн Европын Волга мөрний хавьд амьдарч байсан цөөн тооны (2000 орчим гэр бүл) Унгаруудыг татар болон монголчууд 1236-1237 онд ялж, улсыг эзлэн авав. Унгаруудыг заримдаа таргарууд гэдэг түүний шалтгааныг мэддэггүй. Тэд нар татар-монголчуудын холбоотон байсан байж магадгүй.





цайзууд хүн ам ихтэй болохоор нэг цайз нь л гэхэд 50 мянган зэвсэглэсэн цэрэг гаргах боломжтой.²⁴ Үүний хажуугаар Ведин, Мерувиа, Мурдвин болон Пуйдов улсуудыг ч эзлэв.²⁵ Эдгээр улсад хоёр хан байсан ба нэг хан нь бүх ард түмэнтэйгээ болон гэр бүлтэйгээ хамт татаруудад бууж өгч, эрхшээлд нь орсон бол нөгөө нь маш их сайн хамгаалагдсан цайз болон дүрвэж ирсэн хүмүүсийн хүчээр тэдний эсрэг зогсож чадсан. Тэгээд бид Оросын нутгийн захад хүлээнгээ үнэнийг мэдэж авсан: татаруудын бүх цэрэг нь дөрөв хуваагдан баруун тийшээ явж байгаа. Нэг хэсэг нь Етил мөрний²⁶ хажууд Орос улсын зүүн хэсэгт байх Суздалыг чиглэн явж байгаа бол нөгөө хэсэг нь өмнө зүг Рязанийн²⁷ хил дээр ирсэн. Рязан Рүтэний вант улсыг өмнө хэн ч дийлж байгаагүй. Гурав дахь хэсэг нь Дон мөрний эсрэг талд буй Воронеж цайзын хажууд очин отоглосон ба энэ ч гэсэн Оросын нэгэн вант улс юм.

Дүрвэж яваа тэдгээр рүтэн, болгар ба унгаруудын ярьснаар, татарууд бол дараа жилийн өвөл голын ус, намаг хөлдөхөөр Рүтэн²⁸-ий нутгийг эзэлж авсантай адилхнаар Оросыг ч амархан эзэлнэ гэж төлөвлөсөн. Гэхдээ энэ бүхний зэрэгцээ буюу дайн эхлэх үеэр бүгдийн хаан болох Гүр хаан таалал төгссөнийг мэдэцгээж байна уу. Харин одоо түүний хүү хаан ширээнд сууж, Орнах хотод суурьшиж байна. Энэ хот нь аавынх нь анх эзэлсэн улс юм. Тэрээр дараах байдлаар суурьшин амьдарч байна:

Маш том ордонтой бөгөөд мянган морьтон цэрэг хаалгаар нь зэрэг ордог, ороод мөргөчихөөд мориндоо мордон гардаг. Дээр дурдсан жанжин өөртөө маш том өндөр, алтан хөлтэй орыг ч бэлтгүүлсэн. Энэ орыг хамгийн үнэтэй бүтээлгээр бүтээж, бас л их үнэтэй, нарийн хийцтэй хувцас өмсөн сэтгэл хангалуун суудаг. Ордны хаалгыг алтаар хийсэн ба морьтнууд хаалгаар ямар ч асуудалгүй гардаг. Гадны элч нар харин мориор болон явганаар гарч ордог. Ингэхдээ хаалганы босгонд хөлөөрөө хүрвэл түүнийг


24 Саксин бол Ижил мөрний лалын шашны том төв байсан ба тэр нь Болгар улсаас ойрхон, явган явахад 40 хоногийн зайтай.

25 Merowia - Эртний нэгэн угсаатны нэр, мурдвиноос ойрхон байсан бололтой. Ведин нь бургас угсаатны газар нутаг мөн. Пойдовина нь мурдвинуудын өөр нэгэн нэр.

26 Етил мөрөн заримдаа Ижил, заримдаа Дон эсвэл Днестер ч байж болно.

27 Рязан нь Москва хотоос өмнө зүүн талд Ока голын эрэгт оршино. Монгол цэрэг 1237 оны 12-р сарын 21-нд эзлэн авав.

28 Рүтэн нь одоогийн Украйны баруун хэсэгт хамаарагдана.





яг тэр дор нь сэлмээр цавчиж цаазалдаг учраас гадны хэн боловч хаалгаар маш хүндэтгэлтэйгээр гарах ёстой.

Ингэж маш сүр жавхлантайгаар хаан ширээнд суусан тэрээр цэргээ янз бүрийн газар нутаг руу илгээж, тэнгисийн цаана юу болсныг та бүхэн сонссон байх. Өөр бас нэгэн их цэргийг Унгарын нутаг дэвсгэр рүү зугтаасан куманууд руу явуулав. Гуравдахь цэрэг нь харин Орос улс руу довтолсныг би өмнө бичсэн.

Гэхдээ тэдний дайны тактик болох байлдан харвалдах арга ухаан нь бусдаас хол илүү. Тулалдааны эхэнд тэд харвадаггүй, гэхдээ дараа нь суман бороо орж буй мэт болдог. Сэлэм болон жадаар тэд тийм сайн тулалддаггүй. Цэргийн зохион байгуулалт нь арван хүнийг нэг татар дарга, зуун хүний дээр мөн нэгэн зуутын дарга байдаг. Яагаад ингэдэг вэ гэвэл, гадны туршуулууд тэдний дунд орох боломжгүй болохоос гадна хэрвээ тулааны үеэр цэргийн тоо багасвал ойр хавиас нөхөж оруулах арга хэмжээ авдаг. Янз бүрийн хэл, угсаа гаралтай хүмүүс байдаг хэдий ч тулааны үеэр ямар нэгэн үнэнч бус байдлыг гаргаж чаддаггүй. Эзлэгдсэн улсуудын хаад, ноёд хаа нэгтээ бослого, эсэргүүцлийг зохион байгуулах гэж байгаа нь нотлогдвол ямар ч өршөөлгүйгээр тэднийг цаазалдаг. Олзны цэргүүд болон бие томтой тариачдыг зэвсэглэн, өмнөө тууж тулалдаанд оруулдаг. Тулалдаж чадахгүй тариачдыг газар хагалуулахаар үлдээх ба олзолсон дайсныхаа эхнэр, охин ба бусад эмэгтэй хамаатнуудыг тариачдад хуваан өгдөг. Заримдаа арав болон түүнээс илүү хүмүүсийг хөөж явуулан, цаашдаа өөрсдийгөө татар гэж нэрлэхийг ч шаарддаг байна.

Тулалдаанд хүчээр оруулсан цэргүүд сайн тулалдвал бага зэрэг өршөөл, шан харамж авдаг, харин амиа алдвал хэн ч тэднийг тоодоггүй. Хэрвээ тулалдааны явцад ухарвал татарууд тэднийг шууд алдаг учраас дайчид тулалдаанд эрэлхэгээр амиа алдахыг илүүд үздэг. Цэргүүд зоригтой тулалдаж байгаагийн шалтгаан нь ирээдүйн амьдралынхаа төлөө биш харин хурдан үхэхийн төлөө байдаг. Тэд том хүчирхэг цайз руу шууд дайрахгүйгээр эхний ээлжинд ойр хавийн газар нутгийг сүйтгэн, ард түмнийг нь талан дээрэмдсэний дараа үлдсэнийг нь цуглуулан өөрсдийнх нь цайзыг эзлэн авахад ашигладаг. Татаруудын цэргийн тоо хэмжээний тухай дэлгэрэнгүй бичих боломжгүй, гэхдээ нэг зүйлийг та бүхэнд хэлье: тэд эзэлсэн улсынхаа зэвсэг барьж чадах хүн болгоныг зэвсэглэн өөрсдийнхөө өмнө тууж тулаанд оруулдаг.






Маш олон хүн нэг зүйлийн тухай л ярьж байгаа нь баттай байна, бас Суздалын ван Унгарын хаанд надаар дамжуулан аман мэдээ хүргүүлж байна: татарууд өдөр шөнөгүй хуралдаж, загалмайн шашинт Унгар улсыг хэрхэн ялж эрхшээлд оруулах вэ? гэдгийг хэлэлцэж байна. Тэдний төлөвлөгөө ёсоор, тэд цааш явж Ром болон Ромын цаадах газар нутгийг ч эзэлнэ. Ингээд Унгарын хаанд элч илгээв. Тэднийг Суздалын нутагт явж байхад нь Суздалын ван²⁹ тэднийг барьж аваад, манай хаанд явуулсан захиаг нь авсан. Эдгээр элч нарыг би болон миний хамтрагчид харсан. Дээр дурдсан захиаг Суздалын ван надад өгч, би түүнийг Унгарын хаанд дамжуулан өгсөн. Захиаг тэрсүүд бичгээр, татар хэлээр бичсэн байсан учраас Унгарын хаан түүнийг тайлж унших хүнийг хайж олж чадахгүй байх байсан.

Бид нар Керман гэдэг нэртэй нүүдэлчдийн хотын хажуугаар явж өнгөрөхдөө нэг хүнийг олсон: тэр бидэнд орчуулж өгсөн нь ингэж сонсогдов:

“Би бол хаан. Дээд Тэнгэрийн хааны илгээсэн элч ба дэлхий дээр надад захирагдах хүмүүсийг өргөн тэтгэнэ, харин эсэргүүцэгчдийг дарах эрхийг надад өгсөн. Унгарын хаан³⁰ Чамайг би их гайхаж байна. Би чамд 30 дахь удаагаа элчээ илгээж байна, харин чи яагаад хариу захиа болон миний элчийг буцааж явуулахгүй байна вэ? Би чамайг мэднэ, чи бол баян чинээлэг, олон цэрэгтэй, том гүрнийг ганцаараа захирдаг. Тийм учраас чи өөрөө сайн дураараа ирж бууж өгвөл чамд өлзийтэй байх болно. Үүнээс гадна би сонссон: чи миний боол кумануудыг өөрийнхөө эрхшээлд оруулан байлгаж байгаа. Тийм учраас би чамд тушааж байна: тэднийг цаашид өөрийнхөө хажууд битгий байлга бас тэднээс болж надтай битгий дайсагналц. Чамайг бодвол тэд нар надаас зугтахад амархан. Яагаад гэвэл тэд майхан болон гэрт амьдардаг учраас миний гараас мултархад амархан. Харин чи байшинд амьдардаг, чамд цайз болон хотууд байдаг болохоор чи миний гараас мултарч чадах уу?”

29 Суздал хан нь тэр үед Юрий Всеволодович байж тэр нь Владимир-Суздал нэгтсэн ханы зэрэгтэй байв. Тэр 1238 оны 3-р сарын 4-ний монгол цэрэгтэй тулалдсан байлдаанд нас барав.

30 Тухайн үеийн Унгарын хаан IV Бела байв. Тэрээр 1235-1270 хооронд хааны ширээнд суусан.





Бид нар цаашдын явдлыг үл сонирхоно. Дахин Ромын хамба ламын ордонд сууж байхад миний өмнө Их Унгар руу явсан дөрвөн лам “Их Унгар улс руу явах замд Суздалын нутгийн захад буруу номтон хэсэг унгаруудтай тааралдсан, тэд нар татаруудаас зугтаж явсан. Тэд католик шашныг дуртайяа хүлээн зөвшөөрөх байв. Тэднийг Унгар улсад хүрч ирэхийн өмнө дээр дурдсан Суздалын удирдагч сонсоод маш их хилэгнэж, тэдгээр лам нарыг дуудан, Ромын шүтлэгийг унгаруудад дэлгэрүүлэхийг хориглож, дараа нь тэд нарыг өөрийн нутгаасаа хөөв.

Ийм хүндрэлүүд тулгарсан ч тэд замаасаа буцаж, амархан бууж өгөхийг хүсээгүй. Тиймээс тэд Рязан хотоор дамжин Их Унгарын нутаг дахь мурдвинчууд буюу татарчууд руу явав. Тэднээс хоёр лам нь орчуулагчтайгаа хамт тэнд үлдэж, Петр ба Паулус сахиусын баяр³¹-ын үеэр Мурдвиний ханд хүрсэн яг тэр өдөр Мордвиний нэг аймаг нь татаруудад бууж өгсөн. Цаашид нөгөө хоёр хар ламд юу болсон талаар хэн ч мэдэхгүй. Нас барсан уу? эсвэл дээр дурдсан хан татаруудад тэднийг хүргэж өгсөн эсэхийг бүү мэд. Үлдсэн хоёр хар лам тэднийг сураггүй болсонд санаа зовнин, гэгээн Михаил³² сахиусын баярын үеэр амьд эсэхийг тодруулахаар нэг орчуулагчийг явуулсан ч, түүнийг мурдвинууд алав. Би харин хамтрагчидтайгаа хамт татаруудын эзэлсэн газруудыг нүдээрээ харан, ямар ч үр дүнгүйгээр Унгарт буцаж ирсэн. Бид маш их цэрэг болон дээрэмчдийн дундуур явахдаа шашныхаа мөргөл ба залбирал, нигүүлслийн хүчээр өөрийн сүмдээ бүрэн бүтэн буцаж ирэв.

Ташрамд хэлэхэд, Тэнгэрийн ташуур³³ хүрч ирсэн ийм үед Христосын шүтлэгт бурханы хөвгүүдийн төлөө бид юу хийж чадах билээ?


Үүний дараа би ямар ч мэдээг мартахгүйн тулд нэгэн Рүтэн элч лам, Ариун номны Заргачийн номноос иш татсаныг Та нарт тэмдэглэн мэдүүлж байна. Тэр номонд, татарууд мидианит нь Цетхимтэй хамт Израелийн эсрэг тулалдаж, Гедееонд ялагдсан тухай бичсэн байна.³⁴ Тэндээс мидианчууд зугтааж, Татар голын

31 1237 оны 6-р сарын 29-нд

32 9-р сарын 27

33 Тэнгэрийн ташуур гэдэг хэллэг нь нүүдэлчдийн тусгай нэр байжээ. Анх Хүннүгийн Аттила хааныг Европын түүхэн сурвалжид ийн нэрлэсэн байна.

34 Ариун номын Шүүгчийн нөс 6, 7. авсан зүйл.






эрэг дээр амьдарч эхэлснээс хойш тэднийг татар гэж нэрлэдэг болов. Татаруудын яриагаар, тэд маш их цэргийг гаргаж чадна, бүх цэргээ 40 хэсэгт хуваан байлдаж болно, дэлхий дээр тэдний эсрэг зогсож чадах нэг ч эзэнт гүрэн байхгүй гэнэ. Тэдний цэрэгт өөр шашинт 260 мянган цэрэг байгаа бөгөөд тэдний 135 мянга нь жинхэнэ шилдэг цэрэг гэнэ. Тэдний хүүхнүүдийн талаар хэлэхэд, эрчүүд шигээ байлдаж чаддаг, хэзээ ч ухардаггүй, нум сум сайн харвадаг, адуу мал сааж чаддаг, тулааны үед хэзээ ч ухардаггүй, эрчүүдээс дутахааргүй тулалддаг. Заримдаа эрчүүд ухарч байхад тэд хэзээ ч тэгдэггүй, өөрсдийгөө золиослон манлайлан тулалддаг гэнэ. Татаруудын аж амьдрал, гарал үүслийн тухай бичсэн захиагаа ингээд дуусгая.

Загалмайн шашны бүх дагагч нарт Унгар улсын хаанаас захидлыг илгээж, Аквилеа хамба ламд³⁵ хүргүүлэхэд тэр цааш нь Брихений хамба лам болон Тирул мужийн гүнд³⁶ дамжуулж, үүнээс цааш загалмайн шүтлэгтэнүүдэд илгээж, тэдэнд анхааруулга болгож, Бурхан Тэнгэрт өршөөл хүсэн мөргөх ёстой гэв. Цаашилбал, уг бичгийг хүлээн авсан хүн бүрт энэ захидал нь үнэн болоод зөв гэдгийг баталъя.

35 Аквилеагийн лам нь Унгарын Бела хааны нагац ах бөгөөд тэр хүн 1216-1218 он хүртэл Унгарын шашны том тушаалтан байсан ба тэндээс гарч, 1218-1251 он хүртэл уг зэргийг авав.

36 Тэр хог нь шашны төв Тирул байв.






НОМ ЗҮЙ

1. Bendefy, László 1936. Az ismeretlen Julianusz. Stephaneum, Budapest. 1937. Fontes authentici itinera (1235–1238) fr. Juliani illustrantes, Budapestini, tab. 35-47, tab. XV-XXIIL;
2. Dörrie, H. 1956. Drei Texte zur Geschichte der Ungarn und Mongolen. Die Missionreisen des fr. Iulianus O.P. ins Ural-Gebiet (1234/5) und nach Russland (1237) und der Bericht des Erzbischofs Peter über die Tartaren. Nachrichten der Akademie der Wissenschaften in Goettingen, 1, Phil.-Hist. Klasse, 125-202.
3. Katona, Tamás (ed) 1983. A tatárjárás emlékezete. Helikon, Budapest.
4. Sinor, Denis, 'Un voyageur du treizième siècle: le Dominicain Julien de Hongrie', BSOAS 14 (1952), pp. 589–602
5. Bretschneider, E. 1910. Mediaeval Researches From Eastern Asiatic Sources: Fragments Towards the Knowledge of the Geography and History of Central and Western Asia From the 13th to the 17th Century. 2 volumes; London: K. Paul, Trench, Trubner and Co.
6. Obrusánszky, Borbála 2018. Attila, Európa ura. Tortoma, Barót.





R. PASSUTH. ÖBÖN

